

1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ КОМПАНИ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хяналтын багц эзэмшигчид

Компанийн хяналтын багцыг Э-Транс ХХК /Монгол улсын хуулийн этгээд/ болон Монголиан Транспортэйшн Холдинг ХХК /Люксембургын вант улсын хуулийн этгээд/ эзэмшдэг.

“Э-Транс” ХХК

“Монголиан Транспортэйшн Холдинг” ХХК

Албан ёсны хаяг: БЗД, 20-р хороо, Туулын БЗД, Амгалан өртөөний байр

Албан ёсны хаяг: Люксембург Эл-2146, Руе Дэ Мэрл, 74

Утас: 245908

Утас: 212-698-9266

Факс: 323754

Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигчид

№	Үүсгэн байгуулагчид	Үйл ажиллагааны чиглэл, байршил	Эзэмшиж буй хувь
1	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани, Монгол	60,00%
2	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургын вант улс	34.28%
3	БиДиПиИЭф ХХК	Хөрөнгө оруулалтын сан, АНУ-д бүртгэлтэй	3.90%
4	Х.Батхишиг	“BLJ” ХХК-ийн захирал	1.82%
Нийт гаргасан хувьцаа			100%


Хүснэгт 7 Хувьцаа эзэмшигчид

Толгой компанийн тухай мэдээлэл


Үнэт цаас гаргагч компанийн толгой компани болох Э-Транс ХХК нь 1997 онд 1 гишүүнтэйгээр байгуулагдсан. Компанийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирал Ч.Энхболд нь төмөр замын инженер бөгөөд Замын-Үүд, Багануурын төмөр замын дэд захирал, УБ төмөр замын газрын хянагч, ачаа тээврийн салбарт ТУУШИН ХХК-д экспорт, транзит тээврийн үйл ажиллагааг 3 жил хариуцан ажилласан.



[Handwritten signature]



[Handwritten signature]



1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ КОМПАНИ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус компани нь төмөр зам, авто зам, агаар, далайн тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба дэлхийн 5 тивд ложистикийн байгууллагуудтай төлөөллийн гэрээгээр хамтран ажилладаг. Улаанбаатар хотод төв оффис, Замын-Үүд, Сүхбаатар аймгуудад салбартай. Бизнесийн үндсэн чиглэл нь Орос, Хятадын хооронд Монголоор дамжуулан тээвэрлэх транзит тээврийн үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 2500 тн бараа бүтээгдэхүүнийг төмөр зам, 100 гаруй захиалгат нислэгээр тээвэрлэсэн.

2007 оноос Ачаа шилжүүлэн ачих терминал байгуулахаар төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг терминал нь 2009 онд ашиглалтанд орсноор үйл ажиллагаагаа явуулж байна.

2011 онд Э-Транс ХХК нь ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаагаа тусгаарлан "Э-Транс Ложистикс" ХК-д шилжүүлсэн.

